



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1109

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын хамтлагийн  
Удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны биеийн тамир, спортын хамтлагийн Удирдах зөвлөлийг хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай.
2. Албаны хамт олны дунд, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллахыг Хамтлагийн ахлагч /Э.Батжаргал/-д, дэмжлэг үзүүлж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/38 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 07 сарын 15 өдрийн .....  
А/07..... тушаалын хавсралт



УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Э.Батжаргал	Аудит, дотоод хяналтын хэлтсийн дотоод хяналтын Ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Г.Билгүүн Л.Булган Б.Гэрэл Б.Отгонбат Б.Энхжаргал	Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Аудит, дотоод хяналтын хэлтсийн дотоод хяналтын мэргэжилтэн Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Т.Оюунтөгс	Захиргаа, санхүүгийн хэлтсийн шуурхай ажил хариуцсан Ахлах мэргэжилтэн